

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх зохион байгуулалт, эрх хэмжээг тогтоож, төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, үнэлэх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж

2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар төрийн болон орон нутгийн өмчийг удирдахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулна.

3.2.Төрийн болон орон нутгийн өмчийг удирдахтай холбоотой харилцааг холбогдох бусад хуулиар тодорхойлохдоо энэ хуульд заасан зарчим, нийтлэг зохицуулалтыг баримтлах бөгөөд хуулиар зохицуулагдаагүй төрийн болон орон нутгийн өмчийг удирдахтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчилнэ.

3.3.Төрийн болон орон нутгийн өмчтэй холбоотой дараахь харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна:

3.3.1.улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан болон Үндэсний баялгийн сан, Эрдэнэсийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, захиран зарцуулалттай холбоотой харилцаа;

3.3.2.төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс үүсгэн байгуулсан сангийн зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагаа, түүнд тавих хяналттай холбоотой харилцаа;

3.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавихтай холбоотой харилцаа;

3.3.4.энэ хуулийн 7.1.1-7.1.6, 7.2.1, 7.2.3-7.2.5-д заасан төрийн нийтийн өмч, 8.1.1, 8.1.6, 8.1.8-д заасан төрийн тусгайлсан өмч, 9.2.4-т заасан орон нутгийн өмчийн бүртгэл, тооллогыг зохион байгуулах, өмчийг ашиглуулах болон түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцаа;

3.3.5.төрийн болон орон нутгийн өмчийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр ашиглуулахтай холбоотой харилцаа;

3.3.6.Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далай ашиглахтай холбоотой харилцаа;

3.3.7.хууль болон гэрээний дагуу төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцаа.

3.4.Төрийн болон албаны нууцад хамаарах өмчийг удирдах үйл ажиллагаа, түүнд хяналт тавих журмыг энэ хууль болон холбогдох хуульд нийцүүлэн Засгийн газар батална.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."төрийн байгууллага" гэж төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг дээд, төв болон орон нутгийн бүх шатанд хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасны дагуу байгуулагдсан, төсвөөс санхүүждэг байгууллага, түүний харьяа нэгжийг;

4.1.2."албан газар" гэж төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах нийтийн үйлчилгээ болон төрийн байгууллагын хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэх зорилготой, үйл ажиллагаа, өмчлөх эрхээ төрөөс тогтоосон журмын дагуу хэрэгжүүлж, төсвөөс олгосон хөрөнгө болон өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүждэг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг;

4.1.3."өмчийг удирдлага" гэж хуульд заасны дагуу өмчлөгч болон түүнээс эрх олгосон этгээдээс хэрэгжүүлэх төрийн болон орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг;

4.1.4."хөрөнгийг удирдах" гэж өөрийн эзэмшилд байгаа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хууль болон гэрээнд заасан зориулалт, нөхцөл, журмын дагуу ашиглах болон бусдад ашиглуулах үйл ажиллагааг.

5 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг удирдах зарчим

5.1.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:

5.1.1.төрийн болон орон нутгийн өмч, гадаад улс болон нээлттэй далай тэнгис дэх Монгол Улсын төрийн өмчийг удирдах төрийн бодлого, зарчим нэгдмэл байх;

5.1.2.хуульд заасан зорилго, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн, тооцоо, судалгаанд үндэслэсэн байх;

5.1.3.хуульд заасан үндэслэл, журмын дагуу үр нөлөөтэй, үр ашигтай хэрэгжүүлэх;

- 5.1.4.ил тод, нээлттэй, хариуцлагатай байх;
- 5.1.5.хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол биет болон биет бус хөрөнгийн иж бүрдэл нь нэг эд хөрөнгөд хамаарах бол өмчийн удирдлагыг нэг этгээд хэрэгжүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧ

6 дугаар зүйл.Төрийн өмчийн ангилал

6.1.Төрийн өмч нь төрийн нийтийн болон төрийн тусгайлсан өмчөөс бүрдэнэ.

7 дугаар зүйл.Төрийн нийтийн өмч

7.1.Монгол Улсын үндсэн хууль, бусад хуулиар ард түмний мэдэлд байхаар заасан дараахь байгалийн баялаг, хөрөнгө нь төрийн нийтийн өмч байна:

- 7.1.1.Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар;
- 7.1.2.газрын хэвлий, түүний баялаг;
- 7.1.3.ой, түүний нөөц, дагалдах баялаг;
- 7.1.4.ус, түүний нөөц, доторх баялаг;
- 7.1.5.ан амьтан;
- 7.1.6.Эрдэнэсийн сан;
- 7.1.7.Үндэсний баялгийн сангийн хөрөнгө.

7.2.Монгол Улсын үндсэн хууль, бусад хуулиар төрийн хамгаалалтад байхаар заасан дараахь баялаг, хөрөнгө төрийн нийтийн өмчид хамаарна:

- 7.2.1.ургамал;
- 7.2.2.агаар;
- 7.2.3.агаарын орон зай;
- 7.2.4.хувь хүн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаагаас бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал;
- 7.2.5.археологи, палеонтологийн олдвор;
- 7.2.6.нийтийн зориулалтаар ашиглахаар хуульд заасан бусад өмч.

7.3.Монгол Улсын иргэн нь бусдад эзэмшүүлж, ашиглуулснаас бусад газар, ой, усны сан бүхий газарт чөлөөтэй нэвтрэх, энэ хуулийн 7.1.3-7.1.5, 7.2.1-7.2.3, 7.2.6-д заасан төрийн нийтийн өмчийг хуульд заасны дагуу хувийн болон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар ашиглах, үр шимийг хүртэх эрхтэй.

7.4.Төрийн нийтийн өмчийн газрыг хуульд заасан болзол, журмын дагуу Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэх, эд юмсын хязгаарлагдмал эрхийн үндсэн дээр гадаадын иргэн, харьяалалгүй хүн, олон улсын болон гадаадын хуулийн этгээдэд төлбөр, хугацаатай ашиглуулж болно.

8 дугаар зүйл.Төрийн тусгайлсан өмч

8.1.Төрийн тусгайлсан өмчид дараахь хөрөнгө хамаарна:

- 8.1.1.хувь хүн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаагаас бусад түүх соёлын хөдлөх дурсгалт зүйл;
- 8.1.2.төрийн байгууллага, төрийн өмчит албан газрын хөрөнгө;
- 8.1.3.улсын төсвийн хөрөнгө;
- 8.1.4.Засгийн газрын тусгай сан;

- 8.1.5.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төрийн эзэмшлийн хувьцаа;
- 8.1.6.улсын нөөц;
- 8.1.7.төрийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх;
- 8.1.8.төрийн архивын сан хөмрөг болон төрийн үйл ажиллагаанд хамаарах хуульд заасан бүртгэл, мэдээллийн сан;
- 8.1.9.хуульд заасан бусад хөрөнгө.

9 дүгээр зүйл.Орон нутгийн өмч

9.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор өмчтэй байна.

9.2.Орон нутгийн өмчид дараахь хөрөнгө хамаарна:

- 9.2.1.орон нутгийн төсвийн хөрөнгө;
- 9.2.2.орон нутгийн өмчит албан газрын хөрөнгө;
- 9.2.3.Орон нутгийн хөгжлийн сан;
- 9.2.4.орон нутгийн нөөц;
- 9.2.5.орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцаа;
- 9.2.6.орон нутгийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх;
- 9.2.7.хуульд заасан бусад хөрөнгө.

10 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, хэлбэр

10.1.Төрийн болон орон нутгийн өмч нь эдийн болон эдийн бус (эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл) хөрөнгө байна.

10.2.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө нь үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА

11 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

11.1.Улсын Их Хурал нь ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байна.

11.2.Төрийн болон орон нутгийн өмчийн талаар Улсын Их Хурал дараахь бүрэн эрхтэй:

11.2.1.төрийн нийтийн өмчийн үр өгөөжийг ард түмэнд хүртээх стратеги, төрийн болон орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг батлах, биелэлтийг хангуулах асуудлаар Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх;

11.2.2.хуульд заасны дагуу төрийн нийтийн өмчид хөрөнгө олж авах;

11.2.3.төрийн өмчийг удирдах эрхийг хууль тогтоомжийн дагуу Засгийн газарт олгох, өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэх;

11.2.4.төрийн өмчит компани байгуулах стратегийн ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг батлах;

11.2.5.стратегийн ач холбогдол бүхий салбарт төрийн өмчит компани байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотой Засгийн газрын саналыг хэлэлцэж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх;

11.2.6. энэ хуулийн 11.2.5-д заасан компанийн хувьцааны хяналтын багцаас дээш хувийг олж авах, эсхүл хяналтын багцаас доошгүй хувийг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргахтай холбоотой Засгийн газрын саналыг хэлэлцэж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх;

11.2.7.хууль тогтоомжийн дагуу улсын тусгай хэрэгцээ, нийтийн эрх ашгийг үндэслэн орон нутгийн өмчийн хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэн авах;

11.2.8.төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогын дүн, төрийн болон орон нутгийн өмчийн тухайн жилийн хөдөлгөөнийг нэгтгэн тусгасан төлөв байдлын талаарх Засгийн газрын жил бүрийн тайлан\цаашид “өмчийн төлөв байдлын тайлан” гэх\ тай танилцах, холбогдох асуудлаар Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх;

11.2.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

12.1.Засгийн газар нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд төрийн өмчийг удирдах эрхийг хэрэгжүүлж, төрийн өмчийн үр нөлөөтэй, үр ашигтай байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.

12.2.Төрийн болон орон нутгийн өмчийн талаар Засгийн газар дараахь бүрэн эрхтэй:

12.2.1.төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

12.2.2.хууль тогтоомжийн хүрээнд төрийн өмчийг удирдаж, төрийн тусгайлсан өмчийг удирдах эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн харьяа байгууллага, эсхүл бусад этгээдэд шилжүүлэх, өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлж, шаардлагатай асуудлаар үүрэг, чиглэл өгөх, олгосон эрхийг цуцлах;

12.2.3.төрийн тусгайлсан өмчид хөрөнгө олж авах;

12.2.4.төрийн өмчит компанид төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг тогтоох;

12.2.5.Улсын Их Хурлын зөвшөөрлийг үндэслэн энэ хуулийн 11.2.5, 11.2.6-д заасан асуудлаар шийдвэр гаргах;

12.2.6.энэ хуулийн 11.2.4-т зааснаас бусад салбарт төрийн өмчит компани байгуулах, өөрлөн байгуулах, татан буулгах, төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах болон төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах;

12.2.7.төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулах нийтийн үйлчилгээний салбарын жагсаалт болон тодорхой салбарт төрийн болон орон нутгийн өмчит компани байгуулах шалгуур үзүүлэлтийг батлах;

12.2.8.төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, төрийн байгууллага, албан газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх, зориулалтыг нь өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах;

12.2.9.төрийн тусгайлсан өмчийн хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх, шилжүүлсэн хөрөнгөө буцаан авах;

12.2.10.улсын тусгай хэрэгцээ, нийтийн эрх ашгийг үндэслэн газрыг эргүүлэн авах, бусдын өмчийн хөрөнгийг дайчлан авах шийдвэр гаргах;

12.2.11.төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах шийдвэр гаргах, дүнг хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

12.2.12.төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын тайланг хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргах, тайланг Улсын Их Хуралд хүргүүлэх;

12.2.13.хуульд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан хэм хэмжээний акт батлан мөрдүүлэх;

12.2.14.хуульд заасан бусад бүрэн эрх.

12.3.Засгийн газар энэ хуулийн 12.2.5, 12.2.6-д заасан санал гаргах, 12.2.8, 12.2.9-д заасан асуудлыг хэлэлцэхэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг авсан байна.

13 дугаар зүйл.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

13.1.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, Засгийн газрын холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байна.

13.2.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга, орон тооны бус найман гишүүнтэй байна.

13.3.Засгийн газар нь төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтэц, орон тооны дээд хязгаар, гишүүдийн урамшууллыг тогтоож, дарга, гишүүдийг томилж, чөлөөлнө.

13.4.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд дэгийг хуралдаанаар тогтооно. Хуралдааны шийдвэр нь тогтоол, тэмдэглэл хэлбэртэй байна.

13.5.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаас гадна дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13.5.1.төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангах;

13.5.2.энэ хуулийн 12.2.5, 12.2.6, 12.2.8, 12.2.9-д заасан асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх;

13.5.3.Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан хөрөнгө шилжүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт тайлагнах;

13.5.4.төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслэх, төрийн байгууллага, албан газрын эзэмшилд байгаа тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шилжүүлэх, ашиглах боломжгүйд тооцож, данс, бүртгэлээс хасах саналыг хянаж, зөвшөөрөл олгох;

13.5.5.хуульд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогыг зохион байгуулж, нэгдсэн тайланг бэлтгэн Засгийн газарт танилцуулах;

13.5.6.төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын талаарх жил бүрийн нэгдсэн тайлан, цаашид авах арга хэмжээний саналыг бэлтгэн Засгийн газарт танилцуулах;

13.5.7.төрийн өмчит компанийн менежментийн гүйцэтгэлийг үнэлж, зөрчлийг арилгах талаар шаардлага, зөвлөмж өгөх, хуульд заасан үндэслэл байгаа бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагыг солих,

хариуцлага тооцох саналыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх, нэгтгэсэн дүнг Засгийн газарт танилцуулах;

13.5.8.төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт, хөтлөлтийг эрхлэх;

13.5.9.төрийн өмчийн хөрөнгийг удирдах болон хадгалалт, хамгаалалтад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

13.5.10.төрийн өмчийг удирдах эрх, төрийн өмчид хохирол учруулсан асуудлаар төрийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах, хохирол барагдуулах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

13.5.11.төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

13.5.12.төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомжийн талаар төрийн албан хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах чиглэлээр Төрийн албаны зөвлөл болон холбогдох бусад байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

13.5.13.хуульд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан хэм хэмжээний акт батлан мөрдүүлэх;

13.5.14.хуульд заасан бусад.

13.6.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэлд нэгж /цаашид “Орон нутгийн өмчийн газар” гэх/-тэй байна.

13.7.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоож, даргыг нь томилж, чөлөөлнө.

13.8.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, Орон нутгийн өмчийн газарт улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.

13.9.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь улсын ерөнхий байцаагчийн эрхтэй байх бөгөөд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно. Улсын ерөнхий байцаагч нь улсын ахлах болон улсын байцаагчийн эрхийг олгоно.

14 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

14.1.Орон нутгийн өмчийн өмчлөгчийн эрхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлнэ.

14.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн өмчийн талаар дараахь нийтлэг бүрэн эрхтэй:

14.2.1.орон нутгийн өмчид хөрөнгө олж авах;

14.2.2.өөрт хамаарах хөрөнгийг удирдах, захиран зарцуулах;

14.2.3.хуульд заасны дагуу өмчлөх эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн Засаг даргад, эсхүл бусад этгээдэд шилжүүлэх, өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлж, шаардлагатай асуудлаар үүрэг, чиглэл өгөх, олгосон эрхийг цуцлах;

14.2.4.бусдын эзэмшил газрыг аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээг үндэслэн солих, эргүүлэн авах, нөхөн олговор олгох шийдвэр гаргах;

14.2.5.орон нутгийн өмчийн тооллогын дүнг хэлэлцэх, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр Засаг даргад үүрэг, чиглэл өгөх;

14.2.6.хуульд заасан бол орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан хэм хэмжээний акт батлан мөрдүүлэх;

14.2.7.хуульд заасан бусад.

14.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 14.2-т зааснаас гадна орон нутгийн өмчийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.3.1.орон нутгийн өмчит компани байгуулах, татан буулгах, өөрчлөн байгуулах, эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах;

14.3.2.орон нутгийн өмчит компанид хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг томилох;

14.3.3.орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд албан газар байгуулах саналыг Засгийн газарт хүргүүлэх;

14.3.4.орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг худалдах, шилжүүлэх шийдвэр гаргах;

14.3.5.орон нутгийн өмчийн тооллогын нэгдсэн дүн, орон нутгийн өмчит компанийн менежментийн гүйцэтгэлийн дүнг хэлэлцэх, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр Засаг даргад үүрэг, чиглэл өгөх.

14.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 14.2.4, 14.3.1, 14.3.3, 14.3.4-т заасан асуудлаар шийдвэр гаргахдаа Орон нутгийн өмчийн газрын дүгнэлтийг үндэслэл болгоно.

15 дугаар зүйл.Засаг даргын эрх, үүрэг

15.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь орон нутгийн өмчийн талаар дараахь нийтлэг эрх, үүрэгтэй:

15.1.1.хууль болон иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас олгосон эрхийн хүрээнд орон нутгийн өмчийг удирдах эрхийг хэрэгжүүлэх;

15.1.2.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх, тайлагнах;

15.1.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр орон нутгийн өмчит компанид хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хуульд заасны дагуу томилох, чөлөөлөх;

15.1.4.энэ хуулийн 14.2.4-т заасан асуудлаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, 14.3.1, 14.3.3, 13.3.4-т заасан асуудлаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал хүргүүлэх;

15.1.5.орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийг үнэн зөв бүрдүүлж, мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах;

15.1.6.харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд өмчийн тооллогыг зохион байгуулах, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;

15.1.7.орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, орон нутаг дахь төрийн өмчийг удирдах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

15.1.8.энэ хуулийн 14.2.4, 14.2.5, 14.3.1, 14.3.4, 13.3.5-д заасан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн гүйцэтгэлийг хариуцаж, биелэлтийг тайлагнах;

15.1.9.хуульд заасан бусад.

15.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн өмчийн бүртгэл, тооллогын дүн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг бэлтгэн

аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх асуудлаар Орон нутгийн өмчийн газартай хамтран ажиллана.

16 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн газрын чиг үүрэг

16.1.Орон нутгийн өмчийн газар нь дараахь чиг үүрэгтэй:

16.1.1.харьяа орон нутгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зөвлөмж, шаардлага өгөх;

16.1.2.иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн талаар гарах шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

16.1.3.орон нутгийн өмчийн болон орон нутаг дахь төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих;

16.1.4.орон нутгийн өмчийн болон улсын тооллогыг орон нутагт зохион байгуулж, нэгдсэн дүнг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

16.1.5.орон нутгийн өмчийн төлөв байдлын талаарх жил бүрийн нэгдсэн тайлан, цаашид авах арга хэмжээний талаарх дүгнэлт, саналыг бэлтгэн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, Төрийн өмчийн газарт хүргүүлэх;

16.1.6.Мэдээллийн нэгдсэн санд оруулах орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн бүрдүүлэлт, хөтлөлтийг хариуцах;

16.1.7.төрийн өмч, хөрөнгийн удирдлага, хадгалалт, хамгаалалтад хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

16.1.8.энэ хуулийн 14.4-т заасан асуудлаар дүгнэлт гаргаж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлэх;

16.1.9.орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслэх, орон нутгийн өмчит байгууллага, албан газрын эзэмшилд байгаа тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шилжүүлэх, ашиглах боломжгүйд тооцож, данс, бүртгэлээс хасах саналыг хянаж, зөвшөөрөл олгох;

16.1.10.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмч шилжүүлэх, орон нутгийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах, өөрчлөн байгуулах шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлагнах;

16.1.11.орон нутгийн өмчит компанийн менежментийн гүйцэтгэлийг үнэлж, зөрчлийг арилгах талаар шаардлага, зөвлөмж өгөх, хуульд заасан үндэслэл, журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагыг солих, хариуцлага тооцох саналыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх, нэгдсэн дүнг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;

16.1.12.орон нутгийн өмчийг удирдах эрх, орон нутгийн өмчид хохирол учруулсан асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

16.1.13.төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн сурталчлах, төрийн албан хаагчдыг бэлтгэхэд холбогдох байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

16.1.14.хуульд заасан бусад.

16.2.Сум, дүүрэгт энэ хуулийн 16.1.1, 16.1.3, 16.1.4, 16.1.6, 16.1.7, 16.1.13-т заасан чиг үүрэг бүхий орон нутгийн өмчийн асуудал хариуцсан ажилтан ажиллана. Орон нутгийн өмчийн асуудал хариуцсан ажилтанд улсын байцаагчийн эрх олгож болно.

16.3.Тухайн нэгж дэх төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо, төрийн болон орон нутгийн үйлчилгээний байгууллагын төвлөрөл, ачаалал зэргийг харгалзан сум, дүүрэгт Орон нутгийн өмчийн газар байгуулах эсэхийг Засгийн газар шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТҮҮНИЙ ХӨРӨНГИЙН ЭРХ

17 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ангилал

17.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг дараахь байдлаар ангилна:

- 17.1.1.төрийн байгууллага;
- 17.1.2.албан газар;
- 17.1.3.төрийн болон орон нутгийн өмчит компани.

17.2.Энэ хуулийн 17.1.1, 17.1.2-т заасан хуулийн этгээд нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд хамаарах бөгөөд иргэний эрх зүйн чадвар нь хуульд заасны дагуу байгуулагдсанаар үүсч, татан буугдсанаар дуусгавар болно.

17.3.Энэ хуулийн 17.1.2-т заасан хуулийн этгээд нь нь хувийн эрх зүйн хуулийн этгээдэд хамаарах бөгөөд иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.

18 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрх

18.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон хөрөнгийг хууль, дүрэмд заасны дагуу үр ашигтай удирдах, өмчийн бүртгэл, тооллого, дотоодын хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлж, өмчийн талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах, тайлагнах нийтлэг үүрэгтэй.

18.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд өөрт олгогдсон хөрөнгийг дараахь шаардлагын дагуу эзэмшиж, ашиглана:

18.2.1.хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгийн бүртгэл, хувийн хэрэг хөтлөх, улсын бүртгэлд бүртгүүлэх, хөрөнгийн тооллого хийх, санхүүгийн болон статистикийн мэдээ, тайлан гаргах, холбогдох журмын дагуу тайлагнах;

18.2.2.хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, арчлах, зохистой болон аюулгүйн нөөц бүрдүүлэх, эрсдэлээс хамгаалах, даатгуулах;

18.2.3.илүүдэл, ашиглалтгүй хөрөнгийг түрээслэх, хөлслөх, бусад хэлбэрээр үр ашгийг дээшлүүлэх арга хэрэгслийг ашиглах;

18.2.4.өмчлөгч, эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, эрх зөрчигдөхөөс хууль зүйн арга, хэрэгслийг ашиглан хамгаалах;

18.2.5.эд хариуцагчтай хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулах;

18.2.6.дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээг зохион байгуулах;

18.2.7.хөрөнгийн үйлчилгээ, ашиглалтын найдвартай, аюулгүй байдлыг хангаж бусдад гэм хор учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

18.3.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана.

18.4.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс иргэдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээг сайжруулах, нийтэд тустай үйл ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор санг үүсгэн байгуулах, эсхүл тодорхой санд хуульд заасан журмын дагуу хөрөнгө хандивлаж болно. Сангийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хандивласан хөрөнгийн зарцуулалт, ашиглалтад хяналт тавина.

18.5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь мөнгөн хөрөнгөө ажрилжааны банканд байршуулж болно. Төрийн болон орон нутгийн өмчийн мөнгөн хөрөнгийг арилжааны банканд байршуулах журмыг Засгийн газар батална.

18.6.Төрийн байгууллага нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хамаарах тодорхой хөрөнгийн удирдлагыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бусдад этгээдэд шилжүүлж болно. Гэрээгээр шилжүүлэх чиг үүргийн жагсаалтыг Засгийн газар батална.

18.7.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн эзэмшилд байгаа газар эзэмших эрх, хувьцаа болон энэ хуулийн 13.5.4, 16.1.9-д заасан эрх бүхий этгээдийн шийдвэр, зөвшөөрөлгүйгээр холбогдох хөрөнгийг бусдад шилжүүлэх, түрээслэх, данс, бүртгэлээс хасахыг хориглоно.

18.8.Засгийн газар төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилго бүхий төслийн нэгж, ашиглалтын өмнөх захиргааг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн түр хугацаагаар хуулийн этгээдийн эрхгүйгээр байгуулж болно. Төслийн нэгж, ашиглалтын өмнөх захиргаа нь албан газрын нэгэн адил хөрөнгийн эрх эдэлнэ.

18.9.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хөрөнгийн эрхээ холбогдох хуульд заасны дагуу бие даан хэрэгжүүлнэ.

18.10.Төрийн өмчит компанийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Монгол Улсын Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал хэрэгжүүлнэ.

18.11.Энэ хуулийн 18.10-д заасан хувьцаа эзэмшигчийн эрхээ Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрөө, эсхүл эрх бүхий албан тушаалтныг томилж, төлөөллийн журмаар хэрэгжүүлнэ.

19 дүгээр зүйл.Албан газар, түүний хөрөнгийн эрх

19.1.Төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах нийтийн үйлчилгээ болон төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэх зорилгоор албан газрыг байгуулна.

19.2.Албан газрыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох эрх хэмжээг Засгийн газар хэрэгжүүлнэ.

19.3.Засгийн газрын гишүүн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах албан газрын дүрмийг баталж, даргыг нь томилж, чөлөөлнө. Албан газрын дарга нь Төрийн албаны тухай хууль болон холбогдох хуульд заасан шаардлагыг хангасан байна.

19.4.Албан газар нь энэ хуулийн 18.1, 18.2, 18.5-д заасан нийтлэг үүргийг хэрэгжүүлэхээс гадна өөрийн үйл ажиллагааны орлогыг хууль, дүрэмд заасан чиг үүрэгтээ нийцүүлэн захиран зарцуулах эрхтэй байна. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифыг өөрөө бие даан тогтоож болно.

19.5.Албан газар нь өөрт хамаарах тодорхой хөрөнгийг гэрээний үндсэн дээр бусад этгээдэд хязгаарлагдмал эрхтэйгээр шилжүүлж болно.

19.6.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг болон Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагын харьяанд ажиллах албан газрыг холбогдох хуульд заасны дагуу байгуулж, татан буулгах бөгөөд энэ хуулийн 19.2, 19.3-т заасан журам үйлчлэхгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ

20 дугаар зүйл. Төрийн өмчид хөрөнгө олж авах

20.1.Төрийн өмчид дараахь үндэслэлээр хөрөнгө олж авна:

20.1.1.төрийн өмчийн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр шим, ашиг олсны үр дүнд бий болсон хөрөнгө;

20.1.2.төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны орлогоор бий болсон хөрөнгө;

20.1.3.эрх бүхий байгууллагын баталсан төсөв, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу худалдан авсан болон хөрөнгө зарцуулсны үр дүнд шинээр бий болгосон хөрөнгө;

20.1.4.шүүхийн болон шүүхийн бус журмаар шаардах эрх, авлага, хохирлын нөхөн төлбөрт тооцон авсан, даатгалын нөхөн олговорт авсан хөрөнгө;

20.1.5.хандив, тусламж, бэлэглэл, өвлөх, эрх залгамжлах журмаар олж авсан хөрөнгө;

20.1.6.эзэнгүй болон дарагдмал эд хөрөнгө;

20.1.7.зээлээр авсан хөрөнгө;

20.1.8.сольж авсан хөрөнгө;

20.1.9.төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу шинээр бий болсон эд хөрөнгө;

20.1.10.орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн хөрөнгө;

20.1.11.эргүүлэн авсан, сольж авсан газар;

20.1.12.хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан үндэслэл, журмын дагуу шилжүүлэн авсан, дайчлан авсан, хураасан буюу улсын орлого болгосон хөрөнгө;

20.1.13.хуульд заасан бусад.

20.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон эд хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

20.3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн эзэмших этгээдийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн эзэмших этгээдийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

20.4.Дарагдмал эд зүйл болох түүх, соёлын дурсгалт зүйлийг Иргэний хуулийн 118.3-т заасны дагуу төрийн өмчлөлд шилжүүлэн авна.

20.5.Бусад этгээдтэй хамтарч хөрөнгө оруулсан бол төсвөөс санхүүжүүлсэн хувь хөрөнгийн хэмжээгээр төрийн болон орон нутгийн өмчид хамааруулна.

20.6.Энэ хуулийн 20.1.9, 20.1.11, 20.1.12-т заасан журмаар төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах нөхцөл, журмыг хуулиар тусгайлан зохицуулна.

21 дүгээр зүйл.Орон нутгийн өмчид хөрөнгө олж авах

21.1.Орон нутгийн өмчид энэ хуулийн 20.1.3-20.1.9, 20.1.11, 29.1.12-т зааснаас гадна дараахь үндэслэлээр хөрөнгө олж авна:

21.1.1.төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлсэн хөрөнгө;

21.1.2.орон нутгийн өмчийн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр шим, ашиг олсны үр дүнд бий болсон хөрөнгө;

21.1.3.орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйлчилгээ, үйл ажиллагааны орлогоор бий болсон хөрөнгө;

21.1.4.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн өмчид зориулж бэлтгэсэн хөрөнгө.

21.1.5.хуульд заасан бусад.

22 дугаар зүйл.Хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлалын журмаар хөрөнгө олж авах

22.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Төсвийн тухай хууль, Иргэний хуульд заасны дагуу хандив, тусламж, бэлэглэл болон өв залгамжлалын журмаар хөрөнгө олж авч болно.

22.2.Төрийн өмчит хуулийн этгээд нь бэлэг, хандив, буцалтгүй тусламжаар хүлээн авсан хөрөнгийг үнэлгээ тогтоож, данс бүртгэлд тусгах үүрэгтэй.

22.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад бэлэглэсэн, хандивласан, буцалтгүй тусламжаар олгосон хөрөнгийн үнэлэх, зориулалт, ашиглалтын нөхцөлийг харгалзан эзэмших этгээдийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

22.4.Энэ хуулийн 22.3-т заасны дагуу хандив, тусламж, бэлэглэл, өвийн журмаар авсан хөрөнгө нь орон нутагт зориулсан бол уг хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлнэ.

22.5.Монгол Улс, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хэрэгцээ шаардлагагүй, илүү зардал гарах, эсхүл үүрэг хүлээх нөхцөлтэй хөрөнгийг бэлэг, хандив, өвийн журмаар хүлээн авахаас татгалзах эрхтэй.

23 дугаар зүйл.Хураан авах журмаар хөрөнгө олж авах

23.1.Хураан авсан хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл Орон нутгийн өмчийн газар хүлээн авч, зориулалт, ашиглалтын нөхцөлийг харгалзан эзэмших этгээдийг тогтооно.

23.2.Эрх бүхий этгээдийн шийдвэрт хураан авсан хөрөнгийг тодорхой нэг төрийн, эсхүл орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэхээр заасан бол өмчийг тухайн этгээдийн эзэмшилд шилжүүлнэ.

23.3.Хураан авсан мөнгөн хөрөнгийг улсын орлого болгож улсын төсвийн дансанд оруулна.

23.4.Хураан авсан хөрөнгө нь хэрэгцээ, шаардлага хангахгүй, хуулиар хориглосон болон орчиндоо аюултай эд зүйл бол хүлээн авахаас татгалзаж болно.

23.5.Хураан авсан эд зүйлийн үнэлгээ нь бодит байдалтай нийцэхгүй бол үнэлгээг шинээр тогтооно. Шинээр тогтоосон үнэлгээгээр хөрөнгийг бүртгэж, үнэлгээний хувийг тухайн өмчийг хураан авах шийдвэр гаргасан этгээдэд хүргүүлнэ.

23.6.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл Орон нутгийн өмчийн газар нь энэ хуулийн 23.4-т заасны дагуу гаргасан өмчийг хүлээн авахаас татгалзах шийдвэрийг тухайн өмчийг хураан авах шийдвэр гаргасан этгээдэд даруй мэдэгдэнэ.

23.7.Хохирлын нөхөн төлбөрт хураан авсан хөрөнгийн үнэлгээг энэ хуулийн 23.5-д заасны дагуу шинээр тогтоосны улмаас үнийн зөрүү үүссэн, эсхүл хөрөнгийг энэ хуулийн 23.3-т заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан бол төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл Орон нутгийн өмчийн газар хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, ТООЛЛОГО

24 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл

24.1.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг нь дараахь ангилалаар цаасан болон цахим хэлбэрээр хөтөлнө:

24.1.1.төрийн нийтийн өмчийн бүртгэл;

24.1.2.төрийн тусгайлсан өмчийн бүртгэл;

24.1.3.орон нутгийн өмчийн бүртгэл.

24.2.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл нь дараахь мэдээллийг агуулсан байна:

24.2.1.хөрөнгийн бусад хөрөнгөөс ялгаж тодорхойлох мэдээлэл;

24.2.2.тухайн хөрөнгийн удирдлага, хадгалалт, хамгаалалтыг хариуцах эрх бүхий этгээдийн мэдээлэл;

24.2.3.төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн өмчлөх, эзэмших, ашиглах, түүнтэй холбоотой бусад эрх үүссэн, нэмэгдсэн, өөрчлөгдсөн, дуусгавар болсонтой холбогдох мэдээлэл;

24.2.4.хяналтын багцыг эзэмшиж байгаа төрийн болон орон нутгийн өмчит компанийн хөгжлийн богино, дунд, урт хугацааны бизнес, стратеги төлөвлөлт.

24.3.Хөрөнгө бүрт бүртгэлийн дугаарыг олгож, өмчлөх эрхийг баталгаажуулна.

24.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэлийн ангилал, код, маягтын загварыг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлийг үндэслэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

24.5.Энэ хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан бүртгэлийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, 24.1.3-т заасан бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар, өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийн анхан шатны бүртгэлийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хариуцна.

24.6.Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна оршиж болон нээлттэй далай тэнгис дэх Монгол Улсын төрийн өмчийн бүртгэлийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран хөтөлнө.

25 дугаар зүйл.Төрийн нийтийн өмчийн бүртгэл

25.1.Төрийн нийтийн өмчийн бүртгэлийг өмчийн төрөл тус бүрээр нэгтгэн холбогдох хуульд заасны дагуу хөтөлнө.

25.2.Төрийн нийтийн өмчийн бүртгэл хөтлөх нийтлэг журмыг Засгийн газар, хуульд заасан бол өмчийн төрөлжсөн бүртгэл хөтлөх тусгай журмыг холбогдох эрх бүхий этгээд батална.

26 дугаар зүйл.Төрийн тусгайлсан өмчийн бүртгэл

26.1.Төрийн тусгайлсан өмчийн бүртгэлийг дараахь байдлаар төрөлжүүлэн хөтөлнө:

26.1.1.төрийн өмчит хуулийн этгээд, тэдгээрийн өмч, хөрөнгө;

26.1.2.төрийн өмчийн газар, түүний дотор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд эзэмших, ашиглалтад байгаа газар;

26.1.3.компани дахь төрийн эзэмшлийн хувь, хувьцаа;

26.1.4.төрийн өмчид хамаарах соёлын биет өв;

26.1.5.төрийн өмчид хамаарах оюуны өмч;

26.1.6.итгэмжлэл, бусад удирдлагын гэрээгээр шилжүүлсэн төрийн тусгайлсан өмчийн хөрөнгө.

26.1.7.бусад өмч, хөрөнгө, эрх.

26.2.Монгол Улсын улсын нөөцийн бараа, материал, материаллаг зүйлийн бүртгэлийг эрх бүхий байгууллага хуульд заасны дагуу хөтөлж, удирдана.

26.3.Төрийн тусгайлсан өмчийн бүртгэл хөтлөх нийтлэг журмыг Засгийн газар, хуульд заасан бол өмчийн төрөлжсөн бүртгэл хөтлөх тусгай журмыг холбогдох эрх бүхий этгээд батална.

27 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн бүртгэл

27.1.Орон нутгийн өмчийн бүртгэлийг дараахь байдлаар төрөлжүүлэн хөтөлнө:

27.1.1.орон нутгийн өмчит хуулийн этгээд, тэдгээрийн өмч, хөрөнгө;

27.1.2.компани дахь орон нутгийн эзэмшлийн хувь, хувьцаа;

27.1.3.орон нутгийн өмчид хамаарах оюуны өмч;

27.1.4.итгэмжлэл, бусад удирдлагын гэрээгээр шилжүүлсэн орон нутгийн өмчийн хөрөнгө.

27.1.5.бусад өмч, хөрөнгө, эрх;

27.2.Орон нутгийн өмчийн бүртгэл хөтлөх нийтлэг журмыг Засгийн газар, хуульд заасан бол өмчийн төрөлжсөн бүртгэл хөтлөх тусгай журмыг холбогдох эрх бүхий этгээд батална.

27.3.Орон нутгийн нөөцийн бараа, материал, материаллаг зүйлийн бүртгэлийг эрх бүхий байгууллага хуульд заасны дагуу хөтөлж, удирдана.

28 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого

28.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого дараахь төрөлтэй байна:

28.1.1.улсын тооллого;

28.1.2.орон нутгийн өмчийн тооллого;

28.1.3.дотоодын тооллого.

28.2.Улсын болон орон нутгийн өмчийн тооллого явуулах нийтлэг журам, аргачлалыг Засгийн газар, дотоодын тооллого явуулах журам, аргачлалыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

29 дүгээр зүйл.Улсын тооллого

29.1.Улсын тооллогыг дараахь хэлбэрээр зохион байгуулна:

29.1.1.төрийн тусгайлсан өмчийн болон орон нутгийн өмчийн эргэлтийн бус хөрөнгийн(шаардлагатай бол эргэлтийн хөрөнгийг хамруулах) улсын нэгдсэн тооллого;

29.1.2.төрийн нийтийн өмчийн тодорхой төрлийн дагнасан тооллого;

29.1.3.төрийн тусгайлсан болон орон нутгийн өмчийн тодорхой төрлийн дагнасан тооллого;

29.1.4.тодорхой салбарт ашиглагдах төрийн болон орон нутгийн өмчийн дагнасан тооллого.

29.3.Энэ хуулийн 29.1.1-д заасан тооллогыг 4 жил тутам, 29.1.2-т заасан тооллогыг холбогдох хуульд заасан хугацаанд, 29.1.3, 29.1.4-т заасан тооллогыг Засгийн газрын шийдвэрээр тухай бүр нь зохион байгуулна.

29.4.Улсын тооллогын зохион байгуулалтыг улсын хэмжээнд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн хэмжээнд Орон нутгийн өмчийн газар хариуцна.

29.5.Засгийн газар энэ хуульд заасан журмын дагуу улсын нэгдсэн болон дагнасан тооллогын дүнг Улсын Их Хуралд танилцуулна.

30 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн тооллого

30.1.Орон нутгийн өмчийн тооллогыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр Орон нутгийн өмчийн газар, Засаг дарга хамтран зохион байгуулна.

30.2.Орон нутгийн өмчийн тооллогын зардлыг орон нутаг хариуцна.

31 дүгээр зүйл. Дотоодын тооллого

31.1.Төрийн болон орон нутгийн өмчийн дотоодын тооллогыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага дараахь хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгах үүрэгтэй:

31.1.1.үндсэн, хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт болон барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жил тутам хийж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 31-ний өдрийн дотор;

31.1.2.түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг хагас жил тутам гүйцэтгэж, тайланг тухайн оны 6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор;

31.1.3.дуусаагүй үйлдвэрлэл, өөрийн үйлдвэрийн хагас боловсруулсан зүйл, үнэт цаасны тооллогыг улиралд тутам хийж, тайланг улирлын сүүлийн сарын 25-ны өдрийн дотор;

31.1.4.мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал, бараа, сав, боодлыг сар бүрийн хийж, тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор;

31.1.5. мал, амьтдыг жил тутам хийж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

31.1.6.банкны байгууллагаас бүх төрлийн харилцах дансны хуулгыг тухай бүр нь авч, дансны гүйлгээг шалгаж, улирал бүрийн дансны үлдэгдлийг баталгаажуулах.

31.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хөрөнгийн дотоодын тооллогоор дутагдсан, илүүдсэн хөрөнгө болон цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийн тооцож, хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

32 дугаар зүйл. Тооллого хийхэд бэлтгэх

32.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага тооллого эхлэхийн өмнө дараахь бэлтгэлийг хангах үүрэгтэй:

32.1.1.үндсэн хөрөнгө, түүнд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодох дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх;

32.1.2.бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хөрөнгө хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх;

32.1.3.агуулахад байгаа түүхий эд, материал, бэлэн бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгсэл зэрэг эд хөрөнгийг төрөлжүүлж, хураалт, хадгалалтыг цэгцэлсэн байх;

32.1.4.үйлдвэрлэлийн салбар, нэгжид байгаа хэрэгцээнээс илүү үндсэн хөрөнгө, түүхий эд, хагас боловсруулсан зүйл, бэлэн бүтээгдэхүүн ашиглаж болох хоёрдогч түүхий эд зэргийг агуулахад шилжүүлж гологдол болсон бүтээгдэхүүнийг шийдвэрлэсэн, гүйцэтгэсэн ажлын бүртгэл хөтлүүлж, дуусаагүй ажлын хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажлын хэмжээг тодорхойлсон байх;

32.1.5.мал, амьтныг эзэмшигч бүрээр тоолоход бэлтгүүлэх;

32.1.6.тооллогод хэрэглэгдэх хэмжих багаж, хэрэгслийг шалган баталгаажуулж бараа материалын үнийн болон хэвийн хорогдлын нормын жагсаалтыг үйлдсэн байх;

32.1.7.өмнөх тооллогоор тайлан тэнцлээс хасахаар шийдвэрлэсэн үндсэн хөрөнгө, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн, барааг худалдах, устгах зэргээр бүрэн шийдвэрлүүлж үр дүнг бүртгэлд тусгасан байх;

32.1.8.өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх;

32.1.9.хөрөнгийн мэдээллийн батлагдсан аргачлалын дагуу бүртгэлд тусгасан байх.

33 дугаар зүйл.Тооллогын комисс, түүний эрх, үүрэг

33.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага тооллого эхлэхээс өмнө Тооллогын комисс байгуулна.

33.2.Тооллогын комисс байгуулах шийдвэрт тооллого эхлэх, дуусгах хугацааг тооллого явуулах салбар, нэгж бүрээр заасан байна.

33.3.Улсын тооллогыг хэрэгжүүлэх Тооллогын комиссын ажилд хяналт тавих, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий туслах төлөөлөгчийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага томилж ажиллуулна.

33.4.Тооллогын комисс дараахь эрхтэй:

33.4.1.тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтыг хүлээн авсан эсэхийг шалгах;

33.4.2.тооллого явуулахын өмнө хариуцагчийн хариуцаж байгаа бараа материалын үнэ бүхий зүйл, мөнгөн касс, агуулахыг лацдаж ломбодох болон харуул хамгаалалтын талаар илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээ авахыг холбогдох этгээдээс шаардах;

33.4.3.тооллогын явц дундуур түүхий эд, бараа материал, мөнгөн хөрөнгийг хүлээн авах, тавьж олгох явдлыг бүрэн зогсоох, байгууллагын хэвийн ажиллагааг тасалдуулахгүйн тулд тооллогын комиссын хяналт дор зөвхөн үйлдвэрлэлийн хэрэгцээний зайлшгүй шаардлагатай түүхий эд, материалыг гаргах ба хүлээн авахыг зөвшөөрөх.

33.5.Тооллогын комисс дараахь үүрэгтэй:

33.5.1.хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

33.5.2.тоолсон, хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн жишиг үнэтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

33.5.3.агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, өмнөх тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах;

33.5.4.комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

33.5.5.эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнээс өндөр үнээр авсан, доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг гаргаж, холбогдуулан авах арга хэмжээний талаарх санал гаргах.

33.6.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий /ахлах/ нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж, дансны үлдэгдлийг тулган шалгана.

34 дүгээр зүйл.Өмчийн үнэлгээ

34.1.Төрийн тусгайлсан болон орон нутгийн өмчийн хөрөнгө бүрийн үнэлгээг бүртгэлд тусгасан байна.

34.2.Өмчийг удирдах этгээд нь дараахь ажиллагааг хэрэгжүүлэхийн өмнө тухайн хөрөнгөнд үнэлгээ хийлгэх үүрэгтэй:

34.2.1.хөрөнгийг бусдад худалдаж, шилжүүлэх бол;

34.2.2.компани, санд хувь нийлүүлэх, хөрөнгө оруулах бол;

34.2.3.бусад этгээдээс тухайн өмчид хөрөнгө оруулах бол;

34.2.4.төрийн өмчийн компанийн хувьцааг нийтэд санал болгох бол;

34.2.5.хохирол арилгуулах, нэхэмжлэх бол;

34.2.6.авлагад тооцож хөрөнгө хүлээн авах, өглөгөд тооцож хөрөнгө шилжүүлэх бол;

34.2.7.барьцаа, үүргийн гүйцэтгэлийн баталгаанд тавих бол;

34.2.8.хуульд заасан бусад.

34.3.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь дараахь тохиолдолд хөрөнгийн үнэлгээг хийлгэж болно:

34.3.1.тухайн хөрөнгийн бүртгэлийн үнэ зах зээлийн үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй болсон бол;

34.3.2.ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон боловч цаашид ашиглах боломжтой үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоох бол;

34.3.3.хөдлөх хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусаагүй боловч цаашид ажлын хэрэгцээ шаардлага хангахгүй, эсхүл ашиглах боломжгүй болсон бол;

34.3.4.шаардлагатай бусад.

34.4.Үл хөдлөх хөрөнгө, түүх соёлын дурсгалт зүйлс, биет бус хөрөнгө, хязгаарлагдмал эрхээс бусад дараахь хөрөнгийн үнийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг үндэслэн тухайн байгууллагын удирдлага шинэчлэн тогтоож болно:

34.4.1.ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон боловч цаашид ашиглах боломжтой хөдлөх хөрөнгө;

34.4.2.акталсан боловч бусдад худалдах боломжтой хөрөнгө.

34.5.Төрийн тусгайлсан болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үнэлгээ хийх нийтлэг журмыг Засгийн газар, хуульд заасан бол тодорхой төрлийн хөрөнгөд үнэлгээ хийх тусгай эрх бүхий этгээд батална.

35 дугаар зүйл.Үл хөдлөх хөрөнгө магадлах ажиллагаа

35.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх, худалдахаас өмнө төрийн болон орон нутгийн бусад хэрэгцээнд шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор магадлах ажиллагаа хийнэ.

35.2. Дараахь тохиолдолд магадлах ажиллагаа хийхгүй байж болно:
35.2.1. энэ хуульд заасны дагуу үл хөдлөх хөрөнгийг ашиглуулж байгаа;
35.2.2. үл хөдлөх хөрөнгийг нийтийн хэрэгцээний шугам сүлжээний ажил, улсын болон орон нутгийн чанартай автозамын ажилд ашиглуулж байгаа;
35.2.3. үл хөдлөх хөрөнгөд сервитутын эрх үүсгэж байгаа.

35.3. Магадлах ажиллагааг дараахь байгууллагын төлөөллөөс бүрдсэн баг хэрэгжүүлнэ:

35.3.1. төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд;

35.3.2. хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага;

35.3.3. үл хөдлөх хөрөнгө байрлаж байгаа нутаг дэвсгэрийг харьяалах нутгийн захиргааны байгууллага;

35.3.4. төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн талаар нэгдсэн үйлчилгээ үзүүлэх зорилготой байгууллага;

35.3.5. төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл Орон нутгийн өмчийн газар.

35.4. Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь магадлах ажиллагаа явуулах тухай мэдэгдэл гаргаж нийтэд мэдээлнэ. Магадлах ажиллагааг эхлүүлэхээс өмнө ирүүлсэн үл хөдлөх хөрөнгийг ашиглах тухай хүсэлтийг мэдэгдэлд хавсаргана.

35.5. Сонирхогч этгээдээс тухайн үл хөдлөх хөрөнгийг ашиглах хүсэлт хүлээн авах хугацааг энэ хуулийн 35.4-т заасан мэдэгдлийг нийтлүүлсэн өдрөөс хойш 21 хүртэл хоног байхаар тогтооно.

35.6. Төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлт нь эрх бүхий бусад этгээдээс ирүүлсэн хүсэлтээс давуу эрхтэйд тооцогдоно.

35.7. Үл хөдлөх хөрөнгийн магадлах ажиллагаа явуулах журмыг Засгийн газар батална.

36 дугаар зүйл. Эд хөрөнгийг ашиглах боломжгүй болсонд тооцох

36.1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дараахь тохиолдолд ашиглах боломжгүй болсонд тооцно:

36.1.1. ашиглалт, эдэлгээний хугацаа дууссан ба цаашид ашиглах, хэрэглэх эдийн засгийн үр ашиггүй, эсхүл ашиглалт, хадгалалтын өндөр зардал гарах болсон;

36.1.2. иргэний гүйлгээнд оруулахыг хуулиар хориглосон;

36.1.3. улс, олон нийтийн болон хувь хүний аюулгүй байдалд илт ноцтой сөрөг нөлөө үзүүлэх шинжтэй болсон;

36.1.4. ашиглалт, эдэлгээний хугацаа дуусаагүй боловч цаашид ашиглах, хэрэглэх эдийн засгийн үр ашиггүй болох нь тогтоогдсон, эсхүл ашиглалт, хадгалалтын өндөр зардал гарах болсон;

36.1.5. ашиглалт, эдэлгээний хугацаа дуусаагүй боловч төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хэрэгцээ, шаардлагыг хангахгүй болсон;

36.1.6. бүрэн болон хэсэгчлэн устсан, гэмтсэн, тоногдсон, муудсан, хулгайлагдсан, алдагдсан зэрэг шалтгааны улмаас ашиглах, хэрэглэх, шилжүүлэх боломжгүй болсон.

36.2.Төрийн байгууллага, албан газрын эзэмшилд байгаа тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй болсонд тооцож, данс бүртгэлээс хасах шийдвэрийг тухайн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдийн саналыг, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.

36.3.Энэ хуулийн 36.1.1-36.1.4-т заасан үндэслэлээр тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөс бусад хөдлөх хөрөнгийг ашиглах боломжгүйд тооцож данс, бүртгэлээс хасах шийдвэрийг төрийн байгууллага, албан газрын эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 13.5.4, 16.1.9-д заасан зөвшөөрлийг үндэслэн гаргана.

36.4.Энэ хуулийн 36.1.4-36.1.5-д заасан үндэслэлээр энэ хуулийн 36.3-т зааснаас бусад хөдлөх эд хөрөнгийг ашиглах боломжгүйд тооцох шийдвэрийг тухайн байгууллагын удирдлага нь Өмч хамгаалах зөвлөлийн санал, эсхүл тооллогын комиссын дүгнэлтийг үндэслэн гаргана.

36.5.Энэ хуулийн 36.1.6-д заасан үндэслэлээр хөрөнгө данснаас хасах тохиолдолд буруутай этгээдийг тогтоож, хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

36.6.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглах боломжгүй болсонд тооцох шийдвэрт тухайн хөрөнгийн зураглал, тодорхойлолт, төлөв байдал, шийдвэр гаргасан шалтгаан, үндэслэл болон бусдад шилжүүлэх, устгах хэлбэрийг тодорхой тусгана.

37 дугаар зүйл.Ашиглах боломжгүй хөрөнгийг данснаас хасах

37.1.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон хөрөнгийг бусдад шилжүүлсэн, устгасан, барилга байгууламж бол нурааж буулгасан, сэлбэгээр ашиглах болсон тухай тэмдэглэгээг холбогдох бүртгэл, хувийн хэрэгт хийж, данс бүртгэлээс хасна.

37.2.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон эд хөрөнгийг устгах, нурааж буулгах, ажиллагааг боломжит хамгийн бага зардлаар, хүний эрүүл мэндэд аюулгүй, байгаль орчинд ээлтэй хэлбэрээр гүйцэтгэнэ.

37.3.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон эд хөрөнгийг устгах, данс бүртгэлээс хасах журмыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

37.4.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг буулгаж, данснаас хассан нь төрийн газар эзэмших эрхийг дуусгавар болгох, эсхүл зориулалтыг Засгийн газрын шийдвэргүйгээр өөрчлөх үндэслэл болохгүй.

37.5.Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших, ашиглах эрхийг Засгийн газрын шийдвэргүйгээр данс, бүртгэлээс хасахыг хориглоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЖ, АШИГЛУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

38 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг эзэмшүүлж, ашиглуулах

38.1.Өмчийг удирдах этгээд нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хөлслүүлэх, түрээслүүлэх, узуфрукт, сервитутээр төлбөртэй болон хуульд заасан үндэслэлээр төлбөргүйгээр бусад этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно.

38.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг бусдад ашиглуулах шийдвэр гаргахаас өмнө тухайн үл хөдлөх хөрөнгө төрийн болон орон нутгийн бусад байгууллагад хэрэгцээтэй эсэхийг тогтоох зорилгоор магадлах ажиллагааг явуулна.

38.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг дараахь нөхцөлд төлбөргүй, эсхүл төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулж болно:

38.3.1.албан ажлын хэрэгцээнд зориулан төрийн байгууллагад үнэ төлбөргүй;

38.3.2.албан газрын үйл ажиллагааны зорилго, чиглэл, нийтийн эрх ашгийг харгалзан хөнгөлөлттэй төлбөрөөр;

38.3.3.хууль тогтоомжид заасан тохиолдолд төрийн тодорхой чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй төлбөрөөр.

38.4.Олон улсын төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах зорилгоор төрийн өмчийн хөдлөх эд хөрөнгийг энэ хуулийн 38.3-т заасан үндэслэлээр төлбөртэй болон төлбөргүй ашиглуулж болно.

38.5.Төрийн болон орон нутгийн өмчийг төлбөргүй ашиглаж байгаа бол ашиглагч нь тухайн эд хөрөнгийн элэгдэл, ашиглалтын зардлыг төлнө.

38.6.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө ашиглуулах гэрээний нэгдсэн бүртгэлийг хөтөлнө.

38.7.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулсны төлбөрийг улсын болон орон нутгийн төсөвт оруулна.

38.8.Төрийн өмчийн хөрөнгө ашиглуулах үйл ажиллагаанд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн хөрөнгө ашиглуулах үйл ажиллагаанд Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

38.9.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах журам болон гэрээний үлгэрчилсэн загварыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

38.10.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулахтай холбоотой сонгон шалгаруулалт явуулах, өмчийг төлбөртэй болон төлбөргүй ашиглуулах нөхцөл, төлбөрийн хэмжээ болон хөнгөлөлт тогтоох аргачлал, түрээсийн зүйлд хөрөнгө оруулах асуудлыг энэ хуулийн 38.9-д заасан журмаар зохицуулна.

39 дүгээр зүйл.Өмчийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах

39.1.Төрийн өмчийн газрыг барилга байгууламж барих хязгаарлагдмал эрхээр ашиглуулах тухай шийдвэрт эд юмсын хязгаарлагдмал эрхийн гэрээний нөхцөлийн талаарх мэдээллийг тусгана.

39.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг сервитутээр ашиглуулах тухай шийдвэрт сервитут хэрэгжих талбай, нэвтрэх буюу зорчих хэсгийн зураглалыг хавсаргана.

39.3.Хязгаарлагдмал эрх бүхий этгээд нь уг эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, сервитут тогтоох, уг эрхийн үндсэн дээр баригдсан барилга байгууламжийг гуравдагч этгээдэд ашиглуулахдаа өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчээс зөвшөөрөл авна.

39.4.Төрийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулсан газар дээр барилга байгууламж барих эрхийг харилцан тохиролцсон зорилгоос өөрөөр ашигласан бол өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгоно.

39.5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад олгосон газар дээр иргэн, бусад өмчийн хуулийн этгээдийн барилга барихыг хориглоно.

40 дүгээр зүйл.Эд юмсын хязгаарлагдмал эрхийн гэрээ, төлбөр

40.1.Төрийн болон орон нутгийн өмчид эд юмсын хязгаарлагдмал эрх үүсгэх тухай гэрээ нь хууль, хязгаарлагдмал эрх үүсгэх тухай шийдвэрт нийцсэн байна.

40.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах бол гэрээнд хязгаарлагдмал эрхийн төрөл, агуулгыг тусгана.

40.3.Төрийн болон орон нутгийн өмчид үүсгэсэн эд юмсын хязгаарлагдмал эрхийн төлбөрийг эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн гэрээгээр тохирно.

40.4.Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь гэрээнд заасан нөхцөл байдал өөрчлөгдсөн, эсхүл эд юмсын хязгаарлагдмал эрх үүссэнээс хойш 3 жил тутамд уг эрхийн төлбөрийн хэмжээнд тохируулга хийхийг шаардах эрхтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ ЖУРАМ

41 дүгээр зүйл.Өмчийг шилжүүлэх үндэслэл

41.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг дараахь тохиолдолд хариу төлбөртэй, эсхүл төлбөргүйгээр бусдад шилжүүлж болно

41.1.1.илүүдэлтэй, эсхүл ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг худалдах, зориулалтын дагуу ашиглуулахаар шилжүүлэх;

41.1.2.хөрөнгийг өөр хөрөнгөөр солих;

41.1.3.солилцоо хийсэн хөрөнгийн төлбөрт тооцож өгөх;

41.1.4.өр, бусдад учирсан хохирлыг нөхөн төлсөн;

41.1.5.компанийн хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийх буюу өмч шилжүүлэх замаар төлөх, хувь нийлүүлэх;
41.1.6.эрх бүхий этгээд хөрөнгө худалдах шийдвэр гаргасан;
41.1.7.хандивлах, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх;
41.1.8.хөрөнгийн үр ашгийг нь нэмэгдүүлэх менежментийн гэрээгээр шилжүүлэх;
41.1.9.хуульд заасан бусад.

41.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг түүний бодит үнэлгээтэй тэнцэх хэмжээний төлбөртэйгөөр бусдад шилжүүлнэ.

41.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийг энэ хуулийн 41.1-д зааснаас бусад үндэслэлээр аливаа этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

41.4.Төрийн өмчийн эд хөрөнгөөс нэг удаагийн тэтгэмж, тусламж олгох журмыг Засгийн газар, орон нутгийн өмчийн эд хөрөнгөөс нэг удаагийн тэтгэмж, тусламж олгох журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус батална.

41.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг төлбөргүй, эсхүл үнэлгээнээс доогуур үнээр шилжүүлэн авсан этгээд хөрөнгийг шилжүүлэн авсан зорилгын дагуу ашиглаагүй тохиолдолд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах, хөрөнгийг буцаан авах, хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

42 дугаар зүйл.Өмчийг шилжүүлэх шийдвэр гаргах

42.1.Өмчлөгч, эсхүл хуульд заасны дагуу тухайн хөрөнгийг бусдад шилжүүлэх эрх бүхий этгээд хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх тухай шийдвэр гаргана.

42.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг шилжүүлэх тухай шийдвэр дараахь агуулгатай байна:

- 42.2.1.шилжүүлэхээр төлөвлөж байгаа хөрөнгийн дүрслэл, тодорхойлолт;
- 42.2.2.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад шилжүүлэх болсон хуулийн үндэслэл, шалтгаан, үнэлгээний тайлан, дүгнэлт;
- 42.2.3.хөрөнгийг хүлээлгэн өгөх, өмчлөх эрхийг шилжүүлэх журам;
- 42.2.4.шилжүүлэн өгөх этгээдийг сонгон шалгаруулах арга, тухайн аргыг тогтоосон үндэслэл;
- 42.2.5.худалдах, солих доод үнэ, үнэ тогтоосон аргачлал, төлбөрийн нөхцөл;
- 42.2.6.уралдаант шалгаруулалтаар худалдах бол худалдах бусад нэмэлт нөхцөл;
- 42.2.7.сольж шилжүүлэхээр бол солих нэмэлт нөхцөл;
- 42.2.8.хөрөнгө шилжүүлэх ажлыг зохион байгуулах, төлөөлөн гэрээ байгуулах этгээд, түүний эрх, үүрэг;
- 42.2.9.хөрөнгө шилжүүлэх ажлыг зохион байгуулах зардал, зардлын эх үүсвэр.

42.3.Төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цаасыг шилжүүлэх шийдвэрт тусгагдах нэмэлт нөхцөлийг холбогдох хуулиар зохицуулна.

42.4.Энэ хуулийн 42.1-д заасан этгээд нь өмчийг шилжүүлэх шийдвэр гаргахын өмнө үнэлгээ, үл хөдлөх хөрөнгө бол магадлах ажиллагаа хийлгэж, энэ хуулийн 13.5.2, 16.1.8-д заасан хөрөнгийн талаар дүгнэлт гаргуулсан байна.

43 дугаар зүйл.Өмчийг шилжүүлэх журам

43.1.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдын өмчлөлд дараахь журмаар шилжүүлнэ:

43.1.1.дуудлага худалдаа;

43.1.2.уралдаант шалгаруулалт\төсөл сонгон шалгаруулах;

43.1.2.шууд эзэмшилд шилжүүлэх.

43.2.Шаардах эрх, урлагийн бүтээл зэрэг үнэлгээг нь шууд тогтоох боломжгүй хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг холбогдох хуульд заасан тусгай аргыг ашиглан бусдын өмчлөлд шилжүүлнэ.

43.3.Төрийн болон орон нутгийн өмчийг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур шилжүүлэх, худалдах, хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусдын өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулах, ашиглуулахыг хориглоно.

43.4.Хуульд дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтын журмаар шилжүүлэхээр зааснаас бусад хөрөнгийг энэ хуулийн 41.1.2, 41.1.3, 41.1.4, 41.1.5, 41.1.7-д заасан үндэслэлээр хууль, журмын дагуу бусдын эзэмшилд шууд шилжүүлж болно.

44 дүгээр зүйл.Хөрөнгийг өөр хөрөнгөөр солих

44.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хэрэгцээгүй боловч бусад этгээдэд хэрэгцээтэй хөрөнгийг өөрт хэрэгцээтэй хөрөнгөөр гэрээ байгуулах замаар сольж болно.

44.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн солилцоог нийтийн эрх ашигт нийцсэн, үр ашигтай нөхцөлд хийнэ.

44.3.Хөрөнгийн солилцоо хийх нөхцөл, шаардлагыг ил тод зарлаж, солилцоо хийх этгээдийг нээлттэй сонгон шалгаруулна.

44.4.Хөрөнгийн солилцоо хийхийн өмнө солилцох хөрөнгө тус бүрийн үнэлгээг энэ хуулийн 34.4-д заасан журмын дагуу, үл хөдлөх хөрөнгө бол магадлах ажиллагааг энэ хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу хийнэ.

44.5.Энэ хуулийн 44.4-т заасны дагуу тогтоосон үнэлгээний талаар талууд саналын зөрүүтэй байгаа нөхцөлд үнэлгээг хөндлөнгийн хараат бус үнэлгээчнээр хийлгэнэ.

44.6.Сольж байгаа хөрөнгийн зах зээлийн үнийн зөрүү үл хөдлөх хөрөнгийн хувьд 10 хувиас, хөдлөх эд хөрөнгийн хувьд 30 хувиас хэтрэхгүй байна.

44.7.Солилцож байгаа хөрөнгийн үнийн зөрүүнд хүлээн авсан орлогыг улс, орон нутгийн төсөвт, хэрэв хуульд заасан бол тухайн төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө болно.

44.8.Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг Засгийн газрын зөвшөөрлөөр солино.

44.9.Соёлын биет өв буюу түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийг солилцохыг хориглоно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

45 дугаар зүйл. Дуудлага худалдаа

45.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, бусдын удирдлага, өмчлөлд шилжүүлэхдээ цаашдын зориулалтын талаар тусгайлсан болзол тавих шаардлагагүй тохиолдолд дуудлага худалдааны аргыг хэрэглэнэ.

45.2.Хуульд тусгайлан заасан өмч болон газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг зөвхөн дуудлага худалдааны үндсэн дээр бусдад ашиглуулж, шилжүүлнэ.

45.3.Дуудлага худалдаа явуулах тухай зар мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Орон нутгийн өмчийн газрын болон тухайн өмчийг эзэмшигч байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

45.4.Санал хүлээн авах хугацааг мэдэгдэл гаргасан өдрөөс хойш 14-өөс доошгүй хоног байхаар тогтоох бөгөөд газар эзэмших эрх, үл хөдлөх хөрөнгө болон хувьцааны дуудлага худалдааны талаарх зарыг 30-аас доошгүй хоногийн өмнө мэдээлнэ.

45.5.Энэ хуулийн 45.3-т заасан мэдэгдэлд шилжүүлэх, ашиглуулах хөрөнгө, зориулалт, хөрөнгийн үнэ, эдийн засгийн үр ашгийн үзүүлэлт, хөрөнгийг худалдах доод үнэ, эд хөрөнгө, ажил үйлчилгээний нөхцөл, онцлогтой холбогдох бусад болон гэрээний төслийн талаарх мэдээлэл, дуудлага худалдаа явуулах хугацаа, хураамж, дэнчин ба бусад нөхцөлийг тусгасан байна.

45.6.Дуудлага худалдааны талаар мэдэгдэх, сурталчлах ажлыг энэ хуулийн 45.3-т зааснаас гадна бусад нэмэлт арга хэрэгслээр нийтэд түгээж болно.

45.7.Дуудлага худалдааны тухай нийтэд мэдээлснээс хойш сонирхогч аливаа этгээд зохион байгуулагчийн тогтоосон газар, цагт ашиглуулах, шилжүүлэх хөрөнгийг үзэж, шалгаж болох ба гэрээний нөхцөл, саналтай танилцаж болно.

45.8.Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгөд үзлэг, тооллого хийх бөгөөд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хамгаалах, хөрөнгийг шинэ өмчлөгчид хүлээлгэн өгөх хүртэл хамгаалалтыг хариуцах үүрэгтэй этгээдийг томилж, зөвшөөрөлгүйгээр хөдөлгөөн хийхийг хориглоно.

45.9.Дуудлага худалдаа зохион байгуулах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

45.10.Дуудлага худалдаа зохион байгуулах журмыг Засгийн газар батална.

45.11.Дуудлага худалдааны тайланг батлагдсан загварын дагуу бүрдүүлж, холбогдох байгууллагад хүргүүлж, баримтыг зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.

45.12.Дуудлага, худалдааны дүнг Мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлд оруулж, хөрөнгийн шилжилтийн мэдээллийг улсын бүртгэлийн холбогдох байгууллагад хүргүүлнэ.

46 дугаар зүйл.Хураамж, дэнчин тогтоох

46.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан, эсхүл зохион байгуулах этгээд нь уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаанд оролцох хураамж болон гэрээ байгуулах дэнчингийн хэмжээг тус тус тогтооно.

46.2.Дуудлага худалдаанд оролцох хураамжийг тухайн хөрөнгийн бодит үнийн 2 хувь хүртэл хэмжээгээр тогтоож болно. Энэхүү хураамжийн хэмжээг тогтоохдоо дуудлага худалдаа зохион байгуулах зардал, хүлээгдэж байгаа оролцогчдын тоо зэргийг үндэслэнэ.

46.3.Дуудлага худалдаанд оролцогчийн гэрээ байгуулах үүргийн гүйцэтгэлийн дэнчинд төлөх мөнгөний дүнг тухайн хөрөнгийн бодит үнийн 10 хувь хүртэл хэмжээгээр тогтоож болно.

46.4.Дуудлага худалдаанд оролцогч ялагч болсон боловч зохих хугацаанд гэрээ байгуулаагүй, байгуулахаас татгалзсан, эсхүл гэрээний үүргийг гүйцэтгэх баталгаа гаргаж чадаагүй нөхцөлд дэнчингийн мөнгийг буцаан олгохгүй.

47 дугаар зүйл.Дуудлага худалдааг зохион байгуулах

47.1.Дуудлага худалдааг танхим, эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулна.

47.2.Дуудлага худалдааны нөхцөлийн дагуу хураамж, дэнчинг төлсөн оролцогчдыг урьдчилан бүртгэж, зохион байгуулагчийн тогтоосон цаг, газарт ирж биечлэн оролцох боломжтой дуудлага худалдааг танхимаар зохион байгуулж болно.

47.3.Танхимаар зохион байгуулах дуудлага худалдаанд оролцогчид дуудлага худалдааны нөхцөлийн дагуу тогтоосон өдөр битүүмжилсэн дугтуйнд хийсэн саналаа ирүүлнэ.

47.4.Дуудлага худалдаанд оролцогчийн санал дуудлага худалдааны дүн гартал хүчинтэй гэж тооцогдох ба дуудлага худалдаанд ялагчийн үнийн саналыг гэрээ байгуулах хүртэл хүчинтэй гэж үзнэ.

47.5.Цахим хэлбэрээр дуудлага худалдаа явуулах бол оролцогчид нийтийн харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан хэрэглэгчийн нэрээр дуудлага худалдаа зохион байгуулагчтай холбогдож, дуудлага худалдааны саналаа гаргана. Дуудлага худалдаанд оролцогчийн үнийн санал бусад бүх оролцогчдод нэгэн зэрэг ил харагдах боломжтой байна.

48 дугаар зүйл. Дуудлага худалдааны доод үнэ

48.1. Дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн эд хөрөнгийн санал болгох доод үнийг зохион байгуулагч тухайн хөрөнгийн үнэлгээг харгалзан тогтоох бөгөөд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлийг авна.

48.2. Хоёр дахь дуудлага худалдааны доод үнийг анхны дуудлага худалдааны доод үнийг 20 хүртэл хувиар багасган тогтооно.

48.3. Гурав дахь дуудлага худалдаа, нэмэлт дуудлага худалдаанд доод үнийг тогтоох шаардлагагүй.

49 дүгээр зүйл. Үнэт цаас худалдах

49.1. Төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цаасыг дараахь аргаар худалдаж болно:

49.1.1. үнэт цаасны зохицуулалттай зах зээл дэх нээлттэй арилжаагаар худалдах;

49.1.2. тодорхой төрлийн үнэт цаасыг үнэт цаасны тухай хууль тогтоомжид заасан тусгайлсан арга, хэрэгслээр худалдах;

49.1.3. үнэт цаасыг өөр төрлийн үнэт цаасаар солих.

49.2. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн эзэмшлийн хувьцааг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдана.

49.3. Үнэт цаасны худалдааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулна.

49.4. Үндэсний аюулгүй байдал, стратегийн ач холбогдолтой төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн төрд ногдох хувьцааг худалдах талаар Засгийн газар тусгайлан журам тогтоож болно.

50 дугаар зүйл. Дуудлага худалдааны үр дүнг батлах

50.1. Танхимын аргаар зохион байгуулсан дуудлага худалдааны ялагч ба хоёр дахь дээд үнийн санал гаргагчийн үнийн санал, бүртгэлийн дугаарыг дуудлага худалдааны ялагч тодормогц зарлан мэдэгдэнэ.

50.2. Танхимын аргаар зохион байгуулсан дуудлага худалдааны зохион байгуулагч нь дуудлага худалдааны үр дүн, ялагч болон хоёр дахь дээд үнийн санал гаргагчийн нэрийг дуудлага худалдаа явуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор дуудлага худалдааны бүх оролцогчид бичгээр мэдэгдэнэ.

50.3. Цахим дуудлага худалдааны үр дүнг ялагч тодормогц бүх оролцогчид нийтийн харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан тэр даруй мэдэгдэнэ.

50.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг дуудлага худалдаагаар ашиглуулах, шилжүүлэх тухай шийдвэр гаргасан этгээд дуудлага худалдааны үр дүнг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор дуудлага худалдааг хүчинтэй эсэхийг баталгаажуулна.

50.5. Дараахь тохиолдолд дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзаж, энэ тухай зарлана:

50.5.1. нэг ч оролцогч бүртгүүлээгүй, эсхүл бүртгүүлсэн нэг ч оролцогч дуудлага худалдаанд оролцоогүй;

50.5.2. санал ирээгүй, эсхүл шаардлага хангасан нэг ч санал ирээгүй;

50.5.3. оролцогчид дуудлага худалдаа хөтлөгчийн зааварчилгааг дагаагүй, дуудлага худалдааны журам, дэг зөрчсөн нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн;

50.5.4. дуудлага худалдааны үеэр оролцогчид өөр хоорондоо хуйвалдсан, түүнтэй төсөөтэй үйлдэл гаргасан бөгөөд энэ нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн болох нь илэрсэн;

50.5.5. дуудлага худалдааг зохион байгуулах этгээд, эсхүл дуудлага худалдааны хөтлөгч нь дуудлага худалдаа явуулах журам, дэгийг зөрчсөн дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн;

50.5.6. доод үнэ тогтоогоогүй дуудлага худалдааны хожлын санал нь төр, эсхүл орон нутагт эдийн засгийн үр ашиггүй;

50.5.7. дуудлага худалдаанд ялагч нь дуудлага худалдаанд оролцох эрхгүй этгээд бол.

50.6. Дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзах тухай шийдвэрт шалтгааныг тодорхой тусгана.

50.7. Дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулсан шийдвэрт дуудлага худалдааны ялагчийн нэрийг, ялсан үнийн саналын хамт дурдана. Дуудлага худалдааны бэлэн мөнгөний дэнчинг доод үнийн 5-аас доошгүй хувиар тогтоосон бол шийдвэрт дуудлага худалдаанд хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн этгээдийн нэрийг, үнийн саналын хамт тусгана.

51 дүгээр зүйл. Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах

51.1. Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээд хөрөнгийг ашиглуулах, шилжүүлэх гэрээ байгуулах хугацааг уралдаант шалгаруулалтын үр дүнг баталгаажуулснаас хойш 2 сараас илүүгүй байхаар тогтооно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацааг нэг удаа сунгаж болно.

51.2. Ялагч гэрээ байгуулахаас татгалзсан бол төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээд дуудлага худалдааг хүчингүй гэж зарлаж болно.

51.3. Дуудлага худалдааны ялагч энэ хуульд заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл гэрээний үүргийг гүйцэтгэх баталгаа гаргаж чадаагүй бөгөөд дуудлага худалдааны доод үнийн 5-аас доошгүй хувьтай тэнцэх бэлэн мөнгөөр дэнчин тавьсан бол дуудлага худалдааны хоёр дахь дээд үнийн санал өгсөн этгээд гэрээ байгуулж болно. Энэ тохиолдолд нэг сар хүртэл хугацааны дотор гэрээг байгуулна.

51.4. Хөрөнгийг шилжүүлэхийн өмнө төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл Орон нутгийн өмчийн хэлтэс шинэ өмчлөгчтэй гэрээ байгуулна.

51.5. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгасан байна:

51.5.1. хөрөнгийн нийт үнэ, түүнийг төлөх хугацаа, хэлбэр;

51.5.2.өмчлөх эрхийн гэрчилгээ олгох нөхцөл;
51.5.3.хөрөнгийг шилжүүлэн өгөх газар, хугацаа болон хүлээлцэх ажлыг гүйцэтгэх журам, талуудын эрх, үүрэг;
51.5.4.гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах арга;
51.5.5.хөрөнгийн ашиглалтын талаар хүлээх үүрэг, хариуцлага болон эд хөрөнгийг хүлээн авах, хүлээлгэн өгөх хугацаа, журам зөрчсөний хариуцлага, маргаан шийдвэрлэх журам.

51.6.Гэрээнд хөрөнгө хүлээлгэн өгсөн тухай акт болон холбогдох баримт бичгийг хавсаргана.

51.7.Дуудлагын худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийг өмчлөх эрх нь худалдах, худалдан авах гэрээний зүйлийн үнийг бүрэн төлсний, хэрэв энэ нь үл хөдлөх хөрөнгө бол үнийг бүрэн төлж, үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

52 дугаар зүйл.Дуудлага худалдааг хүчингүйд тооцох

52.1.Дуудлага худалдааг дараахь үндэслэлээр хүчингүйд тооцно:

52.1.1.эрх бүхий этгээдийн шийдвэр, зөвшөөрөлгүйгээр, эсхүл дуудлага худалдааны журам зөрчин зохион байгуулсан;

52.1.2.энэ хуулийн 50.5-д заасны дагуу дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзсан шийдвэр гарсан;

52.1.3.гэрээ байгуулсан этгээд хөрөнгийн үнэ, хууль, гэрээнд заасан бусад төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй;

52.1.4.худалдах доод үнээс бага үнээр худалдсан буюу худалдах, шилжүүлэхийг зөвшөөрөөгүй хөрөнгө оролцуулан авсан, өгсөн;

52.1.5.хөрөнгө шилжүүлэн авсан этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих ёсоор биелүүлээгүй;

52.1.6.шилжүүлсэн хөрөнгийн үнийг төлөхөд хуулиар хориглосон эх үүсвэрийг ашигласан.

52.2.Энэ зүйлийн 52.1-д заасан үндэслэлээр дуудлага худалдааг хүчингүйд тооцох шийдвэрийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт Орон нутгийн өмчийн газар гаргана.

52.3.Дуудлага худалдааг хүчингүйд тооцох шийдвэрт тухайн хөрөнгийг хамгаалах болон цаашид авах арга хэмжээний талаар заана.

АРАВДУГААР БҮЛЭГ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

53 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалт

53.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, шилжүүлэх тусгай болзол шаардлагыг тогтоох бол уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

53.2.Уралдаант шалгаруулалтын зар мэдээллийг шалгаруулалт явуулахаас 60-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

53.3.Уралдаант шалгаруулалтын талаарх зар мэдээлэлд дараахь зүйлийг заавал тусгана:

53.3.1.хөрөнгийн цаашдын ашиглалт, захиран зарцуулалтад тавих нэмэлт болзол, шаардлага;

53.3.2.уралдаант шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүд;

53.3.3.шалгаруулалтад оролцогчдыг урьдчилан бүртгэх хугацаа;

53.3.4.уралдаант шалгаруулалтын төслийг ирүүлэх эцсийн хугацаа;

53.3.5.гэрээний ерөнхий нөхцөл;

53.3.6.дэнчин, хураамжийн хэмжээ.

53.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгийг удирдах үйл ажиллагааг менежментийн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр уралдаант шалгаруулалт явуулж болно.

53.5.Энэ хуулийн 45.3, 45.4, 45.6, 45.7, 45.8, 45.9, 45.11, 45.12-т заасан журам нь уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахад нэгэн адил үйлчилнэ.

53.6.Уралдаант шалгаруулалтын журмыг Засгийн газар батална.

54 дүгээр зүйл.Уралдаант шалгаруулалтын нэмэлт нөхцөл

54.1.Уралдаант шалгаруулалтаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглуулах, бусдын удирдлага, өмчлөлд шилжүүлэхэд дараахь нэмэлт нөхцөл тогтоож болно:

54.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зэрэг байдлаар хөрөнгө оруулалт хийх;

54.1.2.хөрөнгийг тусгай зориулалтаар ашиглах үүрэг хүлээлгэх;

54.1.3.ажилтнуудыг тогтвортой ажиллуулах;

54.1.4.шинэ ажлын байр бий болгох;

54.1.5.тогтоосон шаардлагад нийцсэн техникийн, санхүүгийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;

54.1.6.байгаль орчныг хамгаалах шаардлагыг биелүүлэх;

54.1.7.орон нутгийн иргэдэд шаардлагатай нийтийн үйлчилгээг хүргэх;

54.1.8.төрийн болон орон нутгийн өмчийг уралдаант шалгаруулалтаар ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээдээс тогтоосон бусад нэмэлт нөхцөл.

55 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтын ялагчтай гэрээ байгуулах

55.1.Төрийн болон орон нутгийн өмчийг уралдаант шалгаруулалтаар ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээд ялагчтай гэрээ байгуулна.

55.2.Уралдаант шалгаруулалтын ялагчтай байгуулах гэрээнд дараахь нөхцөлийг тусгана:

55.2.1.үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр хөрөнгө оруулж, технологийг шинэчлэх замаар хуулийн этгээдийн үр ашгийг нь дээшлүүлэх;

55.2.2.хуулийн этгээдийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг нийгэм, бүс нутгийн болон хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлж өөрчлөн байгуулах;

55.2.3.менежментийн гэрээг хэрэгжүүлэгч этгээдээс үйлдвэрлэл, үйл ажиллагааны зохион байгуулалт, технологийн үйл ажиллагааг өөрчлөн байгуулах болон үр ашиг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, үе шат, дүгнэж үнэлэх шалгуур үзүүлэлт, журам болон менежментийн гэрээ хэрэгжүүлэгч этгээдийн цалин хөлс, урамшуулал;

55.2.4.гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн нөхцөлд төрийн өмчийн эд хөрөнгөөс шилжүүлэн өгөх хэмжээ, хэлбэр, үнэ;

55.2.5.гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй нөхцөлд хүлээлгэх хариуцлага, учруулсан хохирлыг нөхөн төлөх хэлбэр, хэмжээ, барьцаалах хөрөнгө.

55.3.Менежментийн гэрээгээр ажиллах этгээд нь гэрээнд заасан бол өөрийн багийг бүрдүүлж болно.

56 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтыг хүчингүйд тооцох

56.1.Уралдаант шалгаруулалтыг дараахь үндэслэлээр хүчингүйд тооцно:

56.1.1.эрх бүхий этгээдийн шийдвэр, зөвшөөрөлгүйгээр зохион байгуулсан;

56.1.2.уралдаант шалгаруулалтын журам зөрчсөн;

56.1.3.уралдаант шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг хангаагүй;

56.1.4.уралдаант шалгаруулалтаар шилжүүлэхийг зөвшөөрөөгүй хөрөнгө оролцуулан авсан, өгсөн;

56.1.5.хөрөнгө шилжүүлэн авсан этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих ёсоор биелүүлээгүй;

56.1.6.шилжүүлсэн хөрөнгийн үнийг төлөхөд хуулиар хориглосон эх үүсвэрийг ашигласан.

56.2.Энэ зүйлийн 56.1-д заасан үндэслэлээр уралдаант шалгаруулалтыг хүчингүйд тооцох шийдвэрийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Орон нутгийн өмчийн газар гаргана.

56.3.Уралдаант шалгаруулалтыг хүчингүйд тооцох шийдвэрт тухайн хөрөнгийг хамгаалах болон цаашид авах арга хэмжээний талаар заана.

57 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтын дараах хяналт

57.1.Уралдаант шалгаруулалтын дараах хяналтыг хөрөнгийн ашиглалтад энэ хуулийн 53.4-т заасан зорилго болон 54.1-д заасан нөхцөл хангагдаж байгаа эсэхийг хянах зорилгоор хэрэгжүүлнэ.

57.2.Төрийн өмчид хамаарах хяналтыг Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн хяналтыг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр Орон нутгийн өмчийн газар хэрэгжүүлнэ.

57.3.Уралдаант шалгаруулалтын дараах хяналтыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батална.

57.4.Хөрөнгийг шилжүүлэн авсан, ашиглаж байгаа этгээд энэ хуулийн 54.1-д заасан нэмэлт нөхцөлийг хожим зөрчих нь уралдаанд шалгаруулалтын үндсэн дээр байгуулсан гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах үндэслэл болно.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГЫН ХЯНАЛТ, ТАЙЛАН

58 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын хяналт

58.1.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт нь өмчлөгчийн хяналт, төрийн хяналт болон хуулийн этгээдийн дотоодын хяналтаас тус тус бүрдэнэ.

58.2.Төрийн өмчийн өмчлөгчийн хяналтыг Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн өмчийн өмчлөгчийн хяналтыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

58.3.Төрийн хяналтыг энэ хуульд заасан журмын дагуу төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Орон нутгийн өмчийн газар хэрэгжүүлнэ.

58.4.Төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн төрийн хяналтыг хэрэгжүүлнэ.

59 дүгээр зүйл.Өмчлөгчийн хяналт

59.1.Энэ хуулийн 58.2-т заасан этгээд нь өмчлөгчийн хяналтыг дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

59.1.1.төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллогын дүн, тайлан, мэдээтэй танилцах, холбогдуулан үүрэг чиглэл өгөх;

59.1.2.төрийн болон орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын үр дүн, хөрөнгийн удирдлагын талаар гаргасан шийдвэр, гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулсан, дүгнэсэн байдалтай танилцаж, үүрэг чиглэл өгөх;

59.1.3.өмчийн чиглэлээр хэрэгжүүлсэн мэргэжлийн болон дотоод хяналт шалгалт, аудитын тайлан, зөрчил, дутагдлыг арилгах талаар авсан арга хэмжээний үр дүнтэй танилцах, үүрэг чиглэл өгөх.

59.2.Өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэгч нь шаардлагатай бол дараахь арга хэмжээг хэрэгжүүлж болно:

59.2.1.өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдээс хөрөнгө олж авсан, хөрөнгийг ашиглах зөвшөөрөл өгсөн, өмчийг удирдсантай холбоотой баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, асуулга, асуулт тавих;

59.2.2.өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийн бүртгэлд оруулсан мэдээлэл үнэн зөв эсэхийг нягтлах зорилгоор газар дээр нь үзлэг, шалгалт хийхийг даалгах;

59.2.3.хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгах чиглэлд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг, даалгавар өгөх.

59.3.Өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийн өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулалтад хяналт тавих, холбогдох тайлан, мэдээллээр хангах үүргийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт харьяа Орон нутгийн өмчийн газар хариуцна.

60 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн төрийн хяналт

60.1.Энэ хуулийн 58.3-т заасан этгээд нь төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг удирдах болон өмчийн хадгалалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

60.1.1.өмчийн бүртгэл, тооллогыг хэрэгжүүлсэн байдал, түүний үр дүнг хянаж, дүгнэлт гаргах;

60.1.2.хуульд заасны дагуу гаргасан тайланг хянаж, дүгнэлт гаргах;

60.1.3.төрийн болон орон нутгийн өмчит компанийн менежментийн гүйцэтгэлийг хянаж, дүгнэлт гаргах;

60.1.4.хөрөнгийн удирдлагын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийх.

60.2.Хяналт шалгалт нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэртэй байх бөгөөд хяналт шалгалтыг харьяаллын дагуу төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл Орон нутгийн өмчийн газрын хяналтын байцаагч хэрэгжүүлнэ.

60.3.Төлөвлөгөөт хяналт шалгалтыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Орон нутгийн өмчийн газрын даргын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.

60.4.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг энэ хуулийн 60.1.1-60.1.3-т заасан хяналтаар илэрсэн алдаа дутагдал, зөрчлийн шалтгааныг тогтоох, эсхүл өмчийг удирдах ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу явуулна.

60.5.Хяналтын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаас гадна дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

60.5.1.хяналт шалгалтыг хууль, журамд заасны дагуу бүрэн гүйцэд хийх;

60.5.2.илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах, хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр хугацаатай үүрэг бүхий албан даалгавар өгөх;

60.5.3.буруутай этгээдэд хариуцлага тооцох, төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагыг солих асуудлаар холбогдох эрх бүхий этгээдэд санал хүргүүлэх;

60.5.4.шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл холбогдох мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх;

60.5.5.төрийн болон орон нутгийн өмчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлаар төрийг шүүхэд төлөөлөн нэхэмжлэх, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

60.5.6.шалгалтын дүн, авсан арга хэмжээний талаар гомдол, мэдээлэл гаргасан этгээдэд мэдэгдэх;

60.5.7.хуульд заасан бусад.

60.6.Хяналтын байцаагч нь хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ дараах ажиллагааг явуулж болно:

60.6.1.ажлын байранд ажлын цагаар нэвтрэн орох;

60.6.2.өмч хөрөнгийг үзэж шалгах, үнэлгээ, шинжилгээ хийлгэх;

60.6.3.холбогдох баримт бичгийг хянах үзэх, түүнийг хуулбарлан авах;

60.6.4.хяналт шалгалттай холбоотой асуулт тавьж, хариулт, тайлбар авах;

60.6.5.шалгалтад шаардлагатай мэдээ, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

60.6.6.хуульд заасан бусад.

60.7.Хяналтын байцаагч нь хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар гүйцэтгэх, төр болон төрийн албан хаагчийн хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, өөрт болон өөрийн хамаарал бүхий этгээдэд холбогдох асуудлыг шалгах аас татгалзах үүрэгтэй.

60.8.Хяналтын байцаагч нь энэ хуулийн дагуу хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлагын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг хариуцна.

60.9.Хянан шалгагч нь энэ хуулийн 60.5.2-т заасан албан даалгаврын биелэлтийг шалгах, 60.5.4-т саналыг шийдвэрлэлтийг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй.

60.10.Хяналт шалгалт явуулах журмыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

60.11.Шаардлагатай бол төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагын оролцуулан баримтын иж бүрэн шалгалтыг хийж болно.

61 дүгээр зүйл.Дотоодын хяналт шалгалт

61.1.Өмчийн дотоодын хяналтыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд энэ зүйлд заасан журмаар өөрөө, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас Төсвийн тухай хуулийн 11.1.11, 12.1.6-д заасны дагуу төсвийн аудит, хяналт шалгалтын журмаар хэрэгжүүлнэ.

61.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий байнгын ажиллагаатай, орон тооны бус Өмч хамгаалах байнгын зөвлөл ажиллана.

61.3.Өмч хамгаалах байнгын зөвлөлийг тухайн байгууллагын даргын шийдвэрээр үндсэн үйл ажиллагаа эрхэлсэн удирдах албан тушаалтан ахалж, нягтлан бодогч, эд хариуцагч, мэргэжлийн /инженер, техникийн зэрэг/ ажилтны бүрэлдэхүүнтэй байгуулна.

61.4.Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллага нь өөрийн салбар, харьяа байгууллага, хуулийн этгээдийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд салбарын хэмжээний төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт, үнэлгээг зохион байгуулж, хийсэн хяналт шалгалтын тайланг жил бүрийн эхний улиралд багтаан төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

61.5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь дотоодын хяналт шалгалтыг жил бүр зохион байгуулж, хяналт шалгалтын тайланг баталгаажуулан тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор Мэдээллийн нэгдсэн санд оруулна.

61.6.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

62 дугаар зүйл.Тайлан

62.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд энэ хуульд заасан холбогдох мэдээ, тайланг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан маягт, зааврын дагуу тухай бүр, хөрөнгийн удирдлагын жилийн тайланг дараа жилийн эхний улиралд багтаан тайлагнах үүрэгтэй.

62.2.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн болон орон нутгийн өмчийн нөөц, хөрөнгийн удирдлага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийн талаар тухайн жилд гарсан хөдөлгөөнийг тусгасан өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг жил бүр гаргаж, дараа жилийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт хүргүүлнэ.

62.3.Засгийн газар нэгдсэн тайланг Улсын Их Хурал, Үндэсний аудитын газарт хүргүүлнэ.

62.4.Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 62.2-т заасан тайланг, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар нь харьяа орон нутгийн өмчийн тайланг байгууллагын цахим хуудсандаа тус тус байршуулна.

62.5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ хуульд заасан чиг үүргийн дагуу гаргасан тайлан мэдээ, бүртгэл, тооллогын дүн, холбогдох бусад мэдээллийг байгууллагынхаа цахим хуудсанд байршуулах үүрэгтэй.

62.6.Хуулиар төрийн болон албаны нууцад хамруулсан мэдээлэл нь энэ хуулийн 62.4, 62.5-д заасан журам хамаарахгүй.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

63 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан

63.1.Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан \цаашид "Мэдээллийн нэгдсэн сан" гэх\-д төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, ангилал, үнэлгээ, өмчийг удирдах этгээд болон өмчийн хөдөлгөөн, тооллого болон холбогдох тайлан, хяналт шалгалтын талаарх мэдээллийг төвлөрүүлнэ.

63.2.Мэдээллийн нэгдсэн сан нь улсын төрөлжсөн бүртгэлийн мэдээлэлд хамаарах бөгөөд баримт бичгийн архив, цахим мэдээллийн сангаас бүрднэ. Мэдээллийн нэгдсэн нь төрийн онцгой объектын зэрэглэлтэй байна.

63.3.Мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг дараахь төрлөөр ангилан тусгана:

63.3.1.төрийн нийтийн ба тусгайлсан өмч, орон нутгийн өмч, хөрөнгийн бүртгэл, тооллогыг дүн, хөдөлгөөн/олж авах, шилжүүлэх, данснаас хасах/, өмчийг удирдах этгээдийн талаарх мэдээлэл;

63.3.2.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээлэл, тайлан;

63.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх, шийдвэр, гэрээний бүртгэл;

63.3.4.төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал, үйл ажиллагааны үр дүн, тайлагнал;

63.3.5.өмчийн хяналт шалгалт, үнэлгээний тайлан;

63.3.6.өмчийн төлөв байдлын жил бүрийн тайлан.

63.4.Мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт, хамгаалалтыг хангах үүргийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

63.5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь холбогдох бүртгэл, мэдээллийг Мэдээллийн нэгдсэн санд тогтоосон хугацаанд бүрэн, үнэн зөв оруулах үүрэгтэй.

63.6.Энэ хуулийн 63.5-д заасан үүргийн хэрэгжилтэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

63.7.Төрийн болон албаны мэдээлэлд хамаарахаас бусад Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл нь олон нийтэд ил тод, нээлттэй байна.

63.8.Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх журмыг Засгийн газар батална.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

64 дүгээр зүйл.Гомдол хянан шийдвэрлэх

64.1.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд нь захиргааны байгууллага, албан тушаалтнаас энэ хуульд заасны дагуу гаргасан шийдвэрт Захиргааны ерөнхий хуулийн 92, 93 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргана.

64.2.Энэ хуулийн 64.1-д заасан гомдлыг хүлээн авсан захиргааны байгууллага Захиргааны ерөнхий хуулийн 94-99 дүгээр зүйлд заасан журмын дагуу гомдлыг шийдвэрлэнэ.

64.3.Иргэн, хуулийн этгээд нь энэ хуулийн 64.2-т заасны дагуу захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

65 дугаар зүйл.Шилжилтийн зохицуулалт

65.1.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн зохион байгуулалтын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах, эсхүл энэ хуулийн 4.1.2-т заасан албан газар, эсхүл Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуульд

заасан компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах эсэхийг Засгийн газар шийдвэрлэнэ.

65.2.Засгийн газрын шийдвэрийн дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах, өөрчлөн байгуулах ажлыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 1 жилийн хугацаанд багтаан зохион байгуулна.

66 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

66.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

66.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

67 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

67.1.Энэ хуулийг 2022 оны ... дүгээр сарын сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг